



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/126/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн
Ерөнхий захирал: Т.Батсайхан
Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com
Аудитын менежер: Г.Оюунгэрэл
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com
Ахлах аудитор: Д.Алтайбаяр
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.6.3 Нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаарлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/158
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.ЭНХБАТ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	222,152,349.78	211,574,833.32
33	АВЛАГА	495,210.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	495,210.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	221,657,139.78	211,574,833.32
351	Түүхий эд материал	3,578,830.00	3,463,305.00
35130	Эм боох материал	3,578,830.00	3,463,305.00
354	Хангамжийн материал	192,483,309.78	181,161,528.32
35410	Бичиг хэргийн материал	6,350,100.00	2,872,600.00
35420	Аж ахуйн материал	141,205,755.00	135,474,523.00
35440	Түлш, шатах тослох материал	24,994,000.00	14,520,000.00
35460	Хүнсний материал	745,220.00	1,917,225.00
35470	Бусад хангамжийн материал	19,188,234.78	26,377,180.32
35600	Мал амьтад	25,595,000.00	26,950,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,285,536,645.64	1,259,128,289.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,285,536,645.64	1,259,128,289.06
392	Биет хөрөнгө	1,129,906,645.64	1,102,723,289.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,137,422,414.10	1,137,422,414.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-178,975,329.49	-260,693,506.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,680,000.00	40,680,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,677,778.04	-14,457,777.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,966,464.00	135,529,990.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-166,002,775.49	-37,259,354.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	157,210,190.00	144,992,876.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-104,160,417.34	-67,366,208.80
39217	Ном	20,443,877.90	23,874,856.54
393	Биет бус хөрөнгө	155,630,000.00	156,404,999.96
39301	Программ хангамж	1,712,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,462,000.00	-50,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	155,380,000.00	155,380,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,507,688,995.42	1,470,703,122.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	780,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	780,000.00
413	Өглөг	00.00	780,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	780,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,507,688,995.42	1,469,923,122.38
51	Засгийн газрын хувь оролцоо	1,507,688,995.42	1,469,923,122.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,212,468,961.00	1,212,468,961.00
51101	Өмч: - төрийн	1,212,468,961.00	1,212,468,961.00
512	Хуримтлагдсан үр дүн	-269,845,927.00	-307,611,800.04
51210	Өмнөх үеийн үр дүн	-269,845,927.00	-269,845,927.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-37,765,873.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	565,065,961.42	565,065,961.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,507,688,995.42	1,470,703,122.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,454,258,635.78	1,476,549,188.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,034,935.78	82,887,657.50
120	Нийтлэг татварын бус орлого	49,034,935.78	82,887,657.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,034,935.78	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,034,935.78	00.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	00.00	60,534,743.64
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	00.00	22,352,913.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,201,200.00	78,251,730.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,307,022,500.00	1,315,409,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,831,000.00	18,504,930.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,859,030.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,831,000.00	3,645,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	95,370,200.00	59,746,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,370,200.00	59,746,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,444,207,331.59	1,513,781,141.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,444,207,331.59	1,513,781,141.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,376,969,830.59	1,430,173,102.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,745,616.00	994,939,255.00
210101	Үндсэн цалин	839,210,772.00	667,592,015.00
210102	Нэмэгдэл	65,864,844.00	267,710,913.00
210104	Урамшуулал	82,670,000.00	59,636,327.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,481,144.00	130,470,792.00
210201	Тэтгэврийн даатгал	85,395,388.00	90,611,692.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,053,156.00	9,964,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,275,400.00	7,971,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,068,800.00	1,993,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,688,400.00	19,929,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,323,600.00	66,974,000.00
210301	Гэрэл, цахилгаан	10,700,000.00	8,372,000.00
210302	Түлш, халаалт	42,020,000.00	54,160,900.00
210303	Цэвэр, бохир ус	2,603,600.00	4,441,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,918,790.00	20,768,441.23
210401	Бичиг хэрэг	564,950.00	703,550.91
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	538,800.00
210404	Ном, хэвлэл	3,013,900.00	3,691,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,542,500.00	719,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,717,800.00	3,968,180.00

210408	Бараа материал акалсны зардал	4,929,640.00	8,146,610.32
2105	Нормативт зардал	30,004,478.00	40,438,604.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,080.00	285,025.00
210502	Хоол, хүнс	29,030,518.00	39,888,919.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	901,880.00	264,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,518,400.00	33,250,610.00
210604	Урсгал засвар	4,518,400.00	33,250,610.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	619,600.00
210702	Дотоод албан томилолт	320,000.00	619,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,718,300.00	4,594,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,118,300.00	3,874,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,939,502.59	138,117,600.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,718,500.00	14,390,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,221,002.59	123,727,600.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,237,501.00	83,608,039.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,815,100.00	43,458,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,819,100.00	43,108,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,996,000.00	350,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	40,149,539.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	40,149,539.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,422,401.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,422,401.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,051,304.19	-37,231,953.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	533,920.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	533,920.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-533,920.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,051,304.19	-37,765,873.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,057,088,961.00	-91,905,148.21	1,131,581,564.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,057,088,961.00	-91,905,148.21	1,131,581,564.12
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-26,596,017.19	-26,596,017.19
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,212,468,961.00	-269,845,927.00	1,507,688,995.42
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,212,468,961.00	-269,845,927.00	1,507,688,995.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,212,468,961.00	-269,845,927.00	1,507,688,995.42
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-37,765,873.04	-37,765,873.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,212,468,961.00	-307,611,800.04	1,469,923,122.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,405,223,700.00	1,393,661,530.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,405,223,700.00	1,393,661,530.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,307,022,500.00	1,315,409,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,831,000.00	18,504,930.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,859,030.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,831,000.00	3,645,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	95,370,200.00	59,746,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,370,200.00	59,746,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,373,398,300.00	1,362,157,030.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,373,398,300.00	1,362,157,030.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,306,160,799.00	1,278,548,991.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,451,535.00	994,444,045.00
210101	Үндсэн цалин	842,207,635.00	667,096,805.00
210102	Нэмэгдэл	70,573,900.00	267,710,913.00
210104	Урамшуулал	82,670,000.00	59,636,327.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,772,088.00	130,470,792.00
210201	Тэтгэврийн даатгал	85,395,388.00	90,611,692.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,344,100.00	9,964,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,275,400.00	7,971,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,068,800.00	1,993,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,688,400.00	19,929,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,303,600.00	56,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	10,700,000.00	8,372,000.00
210302	Түлш, халаалт	46,000,000.00	43,686,900.00
210303	Цэвэр, бохир ус	2,603,600.00	4,441,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,753,300.00	19,743,930.91
210401	Бичиг хэрэг	900,000.00	1,159,550.91
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	538,800.00
210404	Ном, хэвлэл	3,057,900.00	3,691,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,542,500.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,102,900.00	10,754,180.00
2105	Нормативт зардал	46,703,576.00	43,134,124.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,305,400.00	169,500.00
210502	Хоол, хүнс	27,506,076.00	41,060,924.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,892,100.00	1,903,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,870,200.00	7,655,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,409,000.00
210604	Урсгал засвар	34,870,200.00	3,246,800.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	619,600.00
210702	Дотоод албан томилолт	320,000.00	619,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,718,300.00	12,969,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,118,300.00	12,249,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,268,200.00	13,011,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,268,200.00	13,011,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,237,501.00	83,608,039.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,815,100.00	43,458,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,819,100.00	43,108,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,996,000.00	350,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,226,001.00	40,149,539.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,226,001.00	40,149,539.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,196,400.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,196,400.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,825,400.00	31,504,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,825,400.00	31,504,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,825,400.00	31,504,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,825,400.00	31,504,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,825,400.00	31,504,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-31,825,400.00	-31,504,500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,375,156,600.0	1,335,007,061.0	40,149,539.0	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,156,600.0	1,335,007,061.0	40,149,539.0	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,329,491,800.0	1,291,548,561.0	37,943,239.0	97.1

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	996,479,000.0	994,444,045.0	2,034,955.0	99.8
210101	Үндсэн цалин	671,677,700.0	667,096,805.0	4,580,895.0	99.3
210102	Нэмэгдэл	268,841,300.0	267,710,913.0	1,130,387.0	99.6
210104	Урамшуулал	55,960,000.0	59,636,327.0	-3,676,327.0	106.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,524,600.0	130,470,792.0	4,053,808.0	97.0
210201	Тэтгэврийн даатгал	94,665,500.0	90,611,692.0	4,053,808.0	95.7
210202	Тэтгэмжийн даатгал	9,964,800.0	9,964,800.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,971,800.0	7,971,800.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,993,000.0	1,993,000.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,929,500.0	19,929,500.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,500,000.0	56,500,000.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,800,000.0	8,372,000.0	-572,000.0	107.3
210302	Түлш, халаалт	45,000,000.0	43,686,900.0	1,313,100.0	97.1
210303	Цэвэр, бохир ус	3,700,000.0	4,441,100.0	-741,100.0	120.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,343,500.0	15,343,500.0	00.0	100.0
210401	Бичиг хэрэг	743,700.0	743,700.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.0	3,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	538,800.0	538,800.0	00.0	100.0
210404	Ном, хэвлэл	500,000.0	500,000.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.0	600,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,961,000.0	9,961,000.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	68,633,200.0	43,134,124.0	25,499,076.0	62.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	169,500.0	169,500.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	66,560,000.0	41,060,924.0	25,499,076.0	61.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,903,700.0	1,903,700.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,755,800.0	37,555,800.0	6,200,000.0	85.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,409,000.0	14,409,000.0	00.0	100.0
210602	Тавилга	26,100,000.0	19,900,000.0	6,200,000.0	76.2
210604	Урсгал засвар	3,246,800.0	3,246,800.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	775,000.0	619,600.0	155,400.0	79.9
210702	Дотоод албан томилолт	775,000.0	619,600.0	155,400.0	79.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,264,200.0	4,264,200.0	00.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,544,200.0	3,544,200.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,216,500.0	9,216,500.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,216,500.0	9,216,500.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,664,800.0	43,458,500.0	2,206,300.0	95.2

2132	Бусад урсгал шилжүүлэг	45,664,800.0	43,458,500.0	2,206,300.0	95.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,314,800.0	43,108,500.0	2,206,300.0	95.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.0	350,000.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,375,156,600.0	1,335,007,061.0	40,149,539.0	97.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,315,409,800.0	1,275,260,261.0	40,149,539.0	96.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,315,409,800.0	1,275,260,261.0	40,149,539.0	96.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,746,800.0	59,746,800.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	59,746,800.0	59,746,800.0	00.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	87.00	87.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	50.00	50.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	36.00	36.00	00.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,504,930.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,504,930.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,504,930.91
2104	Хангамж, бараа материалын зардал	6,004,930.91
210401	Бичиг хэрэг	415,850.91
210404	Ном, хэвлэл	3,645,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,943,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,705,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,705,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,795,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,795,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,504,930.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,504,930.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,859,030.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,645,900.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод журам, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Г.Оюунгэрэл, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Батсайхан хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Төгс суурь стандарт аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн эрхэм зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Боловсролын салбарын шинэчлэлт, өөрчлөлтийг эрчимжүүлэх, сургалтын технологийн шинэчлэл, сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажил үйлчилгээний чанар үр ашгийг дээшлүүлэх, багш ажилтнуудын хөдөлмөрийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Байгууллага тайлангийн жилд дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаа. Үүнд:

Хүснэгт 1

/сая.төг/

Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Ерөнхий боловсрол-71802	1,299.6	1,259.5	40.1
Насан туршийн боловсрол-71806	15.8	15.8	0,00
Дүн	1,315.4	1,275.3	40.1

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөний дагуу дүгнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн

хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1500 төгрөг”, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1800 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажилласан байна. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2019 оны 12 сарын 18-ний 450 дугаар тогтоол 3,475 төгрөгөөр тогтоосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,444.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 28.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 23.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,362.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 27.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 21.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37.0 сая

төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	00.50	00.00	-0.50
Бараа материал	221.66	211.57	-10.1
Биет хөрөнгө	1,129.91	1,102.72	-27.2
Биет бус хөрөнгө	155.63	156.40	0.8
Нийт хөрөнгө	1,507.69	1,470.70	-37.0
Дансны өглөг	00.00	00.78	0.78
Хуримтлагдсан үр дүн	-269.85	-307.61	-37.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,507.69	1,470.70	-37.0

Мөнгөн хөрөнгө данс нь оны эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр буурсан байгаа нь ажилчидтай холбогдсон татварын урьд оны авлага буурсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 211.6 сая төгрөг болж 10.1 сая төгрөгөөр буурсан нь: 2021 онд 164.0 сая төгрөгийн бараа материал зарцуулсан. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны А/53 тоот тушаалаар бусад хангамжийн материал стем сургалтын хэрэглэгдэхүүн 1.9 сая төгрөг хөрөнгийг данс хооронд шилжүүлсэн,
- Малыг нас дэвшүүлж зарлагдсан 6.9 сая төгрөг,
- Хөвсгөл аймгийн Хатгал тосгон ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны А/40, А/41, А/47 тушаалаар туслах аж ахуйгаас зарцуулсан нийт 0.5 сая төгрөг, эмчийн магадалгаа малыг акталсан 3.2 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 өдрийн А/42 тоот тушаалаар хөрөнгө акталсан 5.0 сая төгрөг.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 27.2 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд материаллаг нөлөөлөл бүхий зардлууд:

- Алаг-Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2021 48 тогтоолоор, 2021 оны 62 тогтоолоор нийт 67.7 сая төгрөг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг хөрөнгийг акталсан.
- Алаг-Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2021 оны 62 тогтоолоор үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг данснаас хасаж 133.0 сая төгрөг болсонтой холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 0.8 сая төгрөгөөр өссөн нь Алаг-Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2021 оны 62 тоот тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1.0 сая төгрөгийн программ хангамжийг дахин үнэлж авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 0.8 сая төгрөгөөр өссөн нь Тогтвортой хөгжлийн боловсрол-2 төслөөр тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 37.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 69.6 сая төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ажил олгогчоос нэмэгдэл цалин өссөн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өссөн, хангамж бараа материалын зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,609.7 сая, орон нутгийн төсвөөс 109.3 сая нийт 1,719.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2021 оны анхны төсвийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,182.1 сая төгрөг, орон нутгаас 59.7 сая төгрөг нийт 1,241.8 сая төгрөг баталсан байна. Тайлант онд төсөвт 2 удаа өөрчлөлт орж, төсвийг нийт 1,375.2 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Төсөвт зардлын санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээс 133.4 сая төгрөгөөр өсгөж баталсан байна. Материаллаг зардлыг тодруулбал:

- Энэ онд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 92.4 сая төгрөг,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12.5 сая төгрөг,
- Хангамж, бараа материалын зардал 8.0 сая төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 2.3 сая төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 2.0 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засвар 33.0 сая төгрөг
- Нэг удаагийн шагнал урамшуулал 0.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Норматив зардал 17.0 сая төгрөгөөр буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан нийт 1,375.2 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байна. Нийт зардлын 1,315.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 59.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,315.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 59.7 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч урсгал үйл ажиллагаанд 1,335.0 сая төгрөгийг зарцуулж, 40.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөр: 71802 Ерөнхий боловсрол

Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх
81835 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах
80109 – ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал
81801 – Үдийн цай хөтөлбөр
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал

Хөтөлбөр: 71806 Насан туршийн боловсрол

Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх

Хүснэгт 3

/сая.төг/

Хөтөлбөр	арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71802	81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	781.3	769.2	12.1	99.4
71802	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	305.8	305.5	0.3	99.9

71802	80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	59.7	59.7	-	100
71802	81801	Үдийн цай хөтөлбөр	45.3	43.1	2.2	95.1
71802	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.4	0.4	-	100
71806	81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	15.8	15.8	-	100

Нийт хөтөлбөрийн биелэлтийг 85.5 хувиар үнэлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны А/54 тоот албан бичгээр түвшин тогтоох шалгалтын материал хувилах, бичиг хэргийн зардал 0.4 сая төгрөг, Боловсролын газрын даргын 2021 оны А/45 тоот албан бичгээр “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс 8.0 сая төгрөг, Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны А/40 тоот албан бичгээр ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 0.44 сая төгрөг, түрээсийн сурах бичгийн төлбөрт 3.6 сая төгрөг, тогтвортой хөгжил-2 төслийн санхүүжилт 6.0 сая төгрөгийг тус тус олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой санхүүгийн тайлангийн тодруулгын тайлбар танилцуулга ихээхэн дутуу байна. Үүнд шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны зорилго зорилттой холбоотой мэдээлэл, санхүүгийн тайланг бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, төсвийн гүйцэтгэлийн тайлбар танилцуулга, онцлох үйл явдлын тодруулга танилцуулга байхгүй байна.

- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас сургалтын хэвийн үйл ажиллагаа хязгаарлагдаж байсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал болох Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 0.24 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: цалин хөлс нэмэгдэл урамшил 0.2 сая төгрөгөөр, батлагдсан төсөвт зардлын 2.9 хувиар буюу 40.6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- 2021 оны 10 сард Монгол хэл уран зохиолын Б.Магван-Эрдэнэ багш өндөр настны тэтгэвэрт гарч багш Э.Уянгыг томилж 2.3 сая төгрөгийн цалин олгосон байна.
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 онд мэдээлбэл зохих 576.4 сая төгрөгийн 46 мэдээллээс 576.2 сая төгрөгийн 46 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав.

Зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын тооллогоор 2 ш төлбөрийн акт тавьсан байна. Үүнд:

- Бодитоор оршин байгаагүй бараа материалд 2.7 сая төгрөгийн актыг 2021 оны 03 сарын 05-ны өдөр Төрийн сан банкны 100170000955 тоот дансанд тушаан барагдуулсан байна.
- Дотуур байрны дулаалгын материал дутууд 30.0 сая төгрөгийн актыг 2021.02.28-ны өдөр гэрээт компани тээвэрлэн авчирч фото, зураг актаар баталгаажуулсан байна. Тус материалаар дотуур байрны байрны урсгал засвар хийгдэж өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар байгууллагын дотоод хяналтын хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Зэрэгцүүлсэн мэдээлэл өмнөх тайлант хугацааны дүн нь өмнөх оны санхүүгийн тайлагналын аудитын дүнтэй дүйцэж буй байдлыг хянахад санхүүгийн байдлын

тайлан дахь хангамжийн материалын зардал өмнөх оны гүйцэтгэлийг зөрүүтэй мэдүүлж тайлагнасныг санхүүгийн байдлын тайланд залруулав.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаарлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5.Энэхүү журмын 1.4 д зааснаас бусад тохиолдолд Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг тухайн байгууллага аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж

Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөх, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр сумын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт" оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын ХЗДХС-ын 2021 оны А/278 дугаар тушаалын 7 дугаар зүйлийн 7.1-т хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг тухайн хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг харьяалах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх сум/тосгоны нэрийг тодорхой болгож Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт"-ийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль	2	0.0	0	0.0	0	0	0	0	2	0